



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/112

Улаанбаатар хот

Аргачлал, шалгуур үзүүлэлт батлах  
тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Салбар, нэгжийн үйл ажиллагаанд иж бүрэн болон биелэлтийн шалгалт зохион байгуулах аргачлал”-ыг нэгдүгээр, “Иж бүрэн болон биелэлтийн шалгалт зохион байгуулах шалгуур үзүүлэлт”-ийг хоёрдугаар, “Шалгуур үзүүлэлтийн хамрах хүрээ”-г гуравдугаар, “Албан тушаалтныг шалгах шалгуур үзүүлэлт”-ийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Шинэчлэгдсэн аргачлал, шалгуур үзүүлэлтийг мөрдөж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (хурандаа Л.Өлзийбаяр), төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч (захирал) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (бригадын генерал, Ц.Ганзориг)-д даалгасугай.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024 оны А/111 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Т.АРИУНБУЯН



1426011100

Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн  
А/... дугаар тушаалын 01 дүгээр хавсралт



## САЛБАР, НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ИЖ БҮРЭН БОЛОН БИЕЛЭЛТИЙН ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГАЧЛАЛ

Нэг. Зорилго.

1.1.Төрийн бодлого, шийдвэр, хууль тогтоомж, байгууллагын хэтийн болон тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, дэвшүүлсэн зорилтыг хангах чиглэлээр Онцгой байдлын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн болон харьяа салбар, нэгжийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, ажил үйлчилгээ, үйл ажиллагаа, алба хаагчдын ажил, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр нөлөө, бүтээмжийг дээшлүүлэх, үр дүнг үнэлэхэд энэ аргачлалын зорилго оршино.

Хоёр. Хамрах хүрээ, бодлого

2.1.Онцгой байдлын ерөнхий газрын харьяа салбар, нэгжийн үйл ажиллагаанд:

2.1.1.Удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт, дотоод үйл ажиллагаа (Цэргийн алба, бие бүрэлдэхүүний сургалт)

2.1.2.Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах ангиллын сургалтын үйл ажиллагаа

2.1.3.Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, гамшигтай тэмцэх үйл ажиллагаа

2.1.4.Санхүүгийн үйл ажиллагаа (Хангалт)

2.1.5.Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламж, логистикийн үйл ажиллагаа

2.1.6.Төрөл мэргэжлийн тусгайлсан үйл ажиллагаа (ОБЕГ-ын харьяа нэгжийн үйл ажиллагаа)

2.1.7.Алба хаагчдын албан тушаалын тодорхойлолтод заагдсан болон мэргэжил ур чадварын түвшин тогтоох үзлэг шалгалтаар авсан ажил арга хэмжээний нийлбэр үнэлгээг хамааруулна.

2.2.Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгж, харьяа салбар, нэгжид иж бүрэн болон биелэлтийн шалгалт зохион байгуулахад тухайн жилийн болон өмнөх 2 жилийн үйл ажиллагаанд шалгалт зохион байгуулж үндсэн чиг үүргийн хүрээнд чиглэл тус бүрээр үнэлнэ.

2.3.Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгж, харьяа салбар, нэгжид иж бүрэн шалгалтын хүрээнд хүргүүлсэн зөвлөмжийн дагуу биелэлтийн шалгалтыг зохион байгуулна.

2.4.Бусад байгууллагын гэрээт, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын бүтцийн нэгжид үйл ажиллагаа явуулж байгаа нэгжид энэхүү аргачлал зааврын холбогдох заалтуудаар удирдамжит шалгалт зохион байгуулна.

2.5. Хяналт шалгалтын давтамж хуваарь, үүссэн нөхцөл байдлыг харгалзан тухайн жилд зохион байгуулах хяналт шалгалтын төлөвлөгөөг Онцгой байдлын ерөнхий газрын даргаар батлуулж, хэрэгжүүлнэ.

### Гурав. Үр дүнг үнэлэх аргачлал

3.1. Аргачлал, шалгуур үзүүлэлтэд тусгагдсан ажил, арга хэмжээг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан үнэлгээний арга зүйг баримтлан нотломжид үндэслэн шалгуур үзүүлэлтийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дараах аргачлалын дагуу хувиар илэрхийлэн үнэлнэ.

3.2. Тухайн ажлын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэхдээ дараах аргачлалын дагуу хувиар илэрхийлж тооцно:

Тухайлбал, хэрэгжүүлбэл зохих 17 ажил, арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн буюу “бүрэн хангалттай” 10 ажил; шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах буюу “хангалттай” 5 ажил; удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй нь баримтаар нотлогдсон буюу “хангалтгүй” 2 ажил үнэлэгдсэн тохиолдолд:

$$\begin{array}{l} 10 \times 100 = 1000 \\ 5 \times 80 = 400 \\ 2 \times 50 = 100 \end{array} \quad \frac{10 \times 100 + 5 \times 80 + 2 \times 50}{17} = 88.2\%$$

3.2.1. Тухайн ажлын зорилт, арга хэмжээний хэрэгжилт 85.0% буюу түүнээс дээш бол "бүрэн хангалттай" (арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн);

3.2.2. Тухайн ажлын зорилт, арга хэмжээний хэрэгжилт 70.0-85.0% хүртэл бол "хангалттай" (шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах);

3.2.3. Тухайн ажлын зорилт, арга хэмжээний хэрэгжилт 70.0% хүртэл бол "хангалтгүй" (удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй нь баримтаар нотлогдсон).

3.3. Онцгой байдлын ерөнхий газрын харьяа салбар, нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт зохион байгуулах чиглэл, шалгуур үзүүлэлтийн жагсаалт:

№	Үйл ажиллагааны үр дүнгийн чиглэл	Үнэлэх үзүүлэлт /тоогоор/	Оноо	Авсан оноо	Нийт оноо
1	Удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт, дотоод үйл ажиллагаа	38	0-100		
2	Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах ангиллын сургалтын үйл ажиллагаа	20	0-100		

3	Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, гамшигтай тэмцэх үйл ажиллагаа	126	0-100		
4	Санхүүгийн үйл ажиллагаа	50	0-100		
5	Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламж, логистикийн үйл ажиллагаа	9	0-100		
6	Төрөл мэргэжлийн тусгайлсан үйл ажиллагаа /ОБЕГ-ын харьяа нэгжийн үйл ажиллагаа/	78	0-100		
7	Албан тушаалтныг шалгах шалгуур үзүүлэлт	Албан тушаалтны тоогоор	0-100		
<b>Нийт оноо</b>		<b>321</b>	<b>0-100</b>		

3.4. Үнэлэх шалгуур үзүүлэлт нь тухайн ажил арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр гаргасан удирдлагын баримт бичигт заагдсан заалт, хугацаа, хүрэх түвшинг харгалзана.

3.5. Тухайн нэгжийн үйл ажиллагааг үнэлэхдээ тушаалын хоёрдугаар хавсралтад заасан үйл ажиллагаа үр дүнгийн чиглэл, шалгуур үзүүлэлтийн заалтын дагуу өгсөн үнэлгээнд, тушаалын дөрөвдүгээр хавсралтын дагуу албан тушаалтнуудыг үнэлсэн дундаж үнэлгээг хамтатган тооцно.

3.6. Албан тушаалтныг шалгах шалгуур үзүүлэлтийн онолын мэдлэгийн шалгалтын тестийг жил бүр, бие бялдрын бэлтгэлжилтийн нормативыг шинэчлэгдсэн тухай бүр Онцгой байдлын ерөнхий газрын чиглэл хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж шинэчлэн гаргаж Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан бүтцийн нэгжид ирүүлнэ.

3.7. Ажлын хэсгээс шалгагдсан нэгжийн үйл ажиллагаа, ололт амжилт, зөрчил дутагдлыг харгалзан ерөнхий үнэлгээг өгөхдөө 3 хүртэлх оноог нэмж, хасаж тооцож болох бөгөөд илтгэх хуудсанд шалтгаан нөхцөлийг дурдаж, нотломжийг хавсаргасан байна.


3.8. Шалгалт зохион байгуулах чиглэлээр Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгжүүд арга зүй, мэдээ, мэдээллээр хангаж, хамтран ажиллана.

Дөрөв. Шалгалтын дүнд гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх

4.1. Шалгагдагч нэгж, албан тушаалтан нь шалгалтын дүн, үнэлгээтэй санал нийлэхгүй тохиолдолд бичгээр гомдол гаргах боломжтой бөгөөд удирдлагын шийдвэрээр томилогдсон ажлын хэсэг хянан шийдвэрлэнэ.

---оОо---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн  
А/... дугаар тушаалын ... дугаар хавсралт  
112



### ИЖ БҮРЭН БОЛОН БИЕЛЭЛТИЙН ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Нэг. Удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт, дотоод үйл ажиллагаа:

№	Үйл ажиллагаа, чиглэл	Шалгуур үзүүлэлт	Авсан оноо	Дундаж оноо	Нийт оноо	
1.1	Бодлого, үйл ажиллагаа, баримт бичгийн хэрэгжилт, үр дүн	1.1.1.Төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилт	1.1.1.1.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх чиглэлээр хийсэн ажил, арга хэмжээ (Алсын хараа 2050, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр г.м)			
			1.1.1.2.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт (Шилэн дансны тухай, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай г.м)			
			1.1.1.3.Байнгын ажиллагаатай зөвлөл, дэд зөвлөл, комисс, (Газар хөдлөлт, Онцгой комисс, Гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл г.м)			
		1.1.2.Дээд шатны байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийн хэрэгжилт	1.1.2.1.Онцгой байдлын ерөнхий газраас тухайн онд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт			
			1.1.2.2.Онцгой байдлын ерөнхий газрын удирдлагаас гаргасан шийдвэр, үүрэг даалгавар, зөвлөмж			
			1.1.2.3.Алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, үр дүн			
			1.1.2.4.Боловсруулсан баримт бичиг, санал, зөвлөмж, оролцоо			
	1.1.2.5. Тайлант хугацаанд ОБЕГ, ЗДТГ-аас өгсөн үнэлгээ, дүгнэлт					
1.2	Үйл ажиллагааны төлөвлөлт	1.2.1.Нэгжийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагаа	1.2.1.1. Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжилт, үр дүн			
		1.2.1.2. Нэгжийн хэмжээнд орон тооны бус байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн үйл ажиллагаа тушаал, шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөө, тайлан, үр дүнг тооцсон эсэх				

			1.2.1.3. Алба хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээ, үнэлгээ			
			1.2.1.4. Хүний нөөцийн бүртгэл, судалгаа			
			1.2.1.5. Хугацаат тайлан мэдээний боловсруулалт, чанар, үр дүн			
			1.2.1.6. Байгууллагын эзэмшил газар, барилга байгууламжийн ашиглалт, паспортжуулалт			
			1.2.1.7. “Яаралтай” болон “Цуглар” дохиогоор ажилласан байдал			
			1.2.1.8. Нэгжийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлийг бууруулах төлөвлөлт, үр дүн			
		1.2.2. Дотоод үйл ажиллагаа	1.2.2.1. Цэргийн албаны зохион байгуулалт			
			1.2.2.2. Төрийн болон албаны нууц хадгалалт, хамгаалалт, хаягжилт			
			1.2.2.3. Нэгжийн хэмжээнд дотоод хяналт, шалгалт зохион байгуулсан байдал			
			1.2.2.4. Нэгдсэн менежментийн тогтолцоо, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын хэрэгжилт, үр дүн /ISO9001:2015, ISO45001:2018/			
			1.2.2.5. Соёл урлаг, спорт, эрдэм шинжилгээ, бусад арга хэмжээ, оролцоо, амжилт			
		1.2.3. Архив, албан хэрэг хөтлөлт, хадгалалт, хамгаалалт	1.2.3.1. Албан хэрэг хөтлөлт, стандарт			
			1.2.3.2. Баримт бичгийн боловсруулалт, цахимжилт			
			1.2.3.3. Баримтын хадгалалт, хамгаалалт, стандарт			
			1.2.3.4. Архивын баримтад тооллого хийсэн байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, алба хаагчдын оролцоо			
			1.2.3.5. Баримт материал хүлээлцсэн байдал, нотломж			
			1.2.3.6. Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудасны ашиглалт, хадгалалт, хамгаалалт			
		1.2.4. Нэгжийн сахилга, ёс зүйн хорооны үйл ажиллагааг зохион	1.2.4.1. Орон тооны бус ёс зүйн албаны төлөвлөгөө, тайлан мэдээ			
			1.2.4.2. Ёс зүйн хурал зохион байгуулалт, шийдвэрийн хэрэгжилт, үр дүн			
			1.2.4.3. Сахилга, дэг журмыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулсан байдал			
			1.2.4.4. Сахилга, ёс зүйн зөвлөгөөн, үр дүн			

		байгуулсан байдал				
		1.2.5. Бие бүрэлдэхүүний сургалтын үйл ажиллагаа	1.2.5.1. Сургалт, бэлтгэлийн төлөвлөгөө, хэрэгжилт, үр дүн			
			1.2.5.2. Зохион байгуулсан сургалтад офицер бүрэлдэхүүний оролцоо, үр чадвар			
			1.2.5.3. Иргэн, байгууллага, хуулийн этгээдийн хамтын ажиллагаа, үр нөлөө			
			1.2.5.4. Сургалт зохион байгуулах орчин нөхцөл бүрдүүлсэн байдал			
			1.2.5.5. Бие бялдрын түвшин тогтоох сорил, биеийн жингийн индексийг тухай бүр авч, үр дүн			
			1.2.5.6. Хичээл, сургалтын тэмдэглэл хөтлөлт, хяналт тавьсан байдал			
			1.2.5.7. Сургалт зохион байгуулсан тайлан, мэдээ, бүрдүүлбэр			
		7	38			

**Хоёр. Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах ангиллын сургалтын үйл ажиллагаа**

№	Үйл ажиллагаа, чиглэл		Шалгуур үзүүлэлт	Авсан оноо	Дундаж оноо	Нийт оноо
2.1	Урьдчилан сэргийлэх сурталчилгаа, олон нийттэй харилцах үйл ажиллагаа	2.1.1. Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг олон нийтэд зохион байгуулсан байдал	2.1.1.1. Урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөлт, сургалт, сурталчилгааны нөлөө, үр дүн /хамрагдалт, давтамж, зорилтот бүлгийн хүрэлтийг хангасан байх/			
			2.1.1.2. Телевиз, сонин, цахим хуудас болон олон нийтийн цахим сүлжээгээр сэрэмжлүүлэг, мэдээлэл түгээсэн байдал, үр дүн			
			2.1.1.3. Орон нутгийн онцлогт тохируулан урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан байдал /өмнөх оны мөн үетэй харьцуулахад гамшиг, осол, аюулт үзэгдлийн дуудлагын тоо буурсан байх/			

			2.1.1.4. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд сайн дурынхны оролцоо, чадавхжуулсан байдал			
			2.1.1.5. Байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчдын ажил мэргэжлийн онцлогийг сурталчилан таниулсан арга хэмжээ, үр нөлөө			
2.2	Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа	2.2.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ	2.2.1.1. Гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ, анхан шатны дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцсон байдал			
			2.2.1.2. Эрсдэлийг бууруулах чиглэлийн сургалт, дадлага зохион байгуулсан байдал, зөвлөмж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн			
			2.2.1.3. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн ААНБ, барилга, байгууламжийн бүртгэл, мэдээллийн сан үүсгэсэн байдал			
			2.2.1.4. Гамшгийн эрсдэлийг бууруулах Олон улсын өдрөөр зохион байгуулсан ажил, арга хэмжээ			
			2.2.1.5. Орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлсэн хөрөнгө, үр дүн			
			2.2.1.6. Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагаа, зохион байгуулалт			
			2.2.1.7. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт /Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг г.м/			
		2.2.2. Гамшгийн эрсдэлийн мэдээллийн сан, зураглал, технологийг нэвтрүүлсэн байдал	2.2.2.1. Эрсдэлийн мэдээллийн нэгдсэн сан, зураглалыг бодлого, төлөвлөлтөд ашигласан байдал			
		2.2.2.2. Гамшгийн орон зайн мэдээллийн системд гамшиг, ослын мэдээллийг оруулсан бүртгэл, хэрэгжилт				
2.3	Гамшгаас хамгаалах ангиллын сургалтын үйл ажиллагаа	2.3.1. Ангиллын сургалт зохион байгуулсан байдал	2.3.1.1. Сургалтын удирдамж, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн			
			2.3.1.2. Сургалт зохион байгуулсан тайлан, мэдээ, цахим бүртгэлд байршуулсан байдал, нотломж			
			2.3.1.3. Зорилтот бүлгийн иргэдэд сургалт зохион байгуулсан байдал, үр дүн			
			2.3.1.4. Сургалтын өмнөх ба дараах мэдлэгийн тестийг авч, үр дүнг тооцсон байдал			

			2.3.1.5. Алслагдсан бүс нутгийн иргэдийг сургалтад хамруулж, үр дүнг тооцсон байдал			
			2.3.1.6. Сургалтын материал бүрдүүлбэр			
		<b>4</b>		<b>20</b>		

**Гурав. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, гамшигтай тэмцэх үйл ажиллагаа**

№	Үйл ажиллагаа, чиглэл	Шалгуур үзүүлэлт	Авсан оноо	Дундаж оноо	Нийт оноо	
3.1	Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдлыг хангах арга хэмжээ	3.1.1. Орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө	3.1.1.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний боловсруулалт, хянуулж батлуулсан эсэх, хэрэгжилт			
			3.1.1.2. Төлөвлөгөөнд тодотгол хийсэн байдал			
			3.1.1.3. Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөний боловсруулалт, үр дүнг тооцсон байдал			
			3.1.1.4. Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөний хавсралт судалгаа /нисдэг тэрэг буух, хөөрөх талбай, хоргодох байр, цугларах цэг, нүүлгэн шилжүүлэх талбай г.м/			
			3.1.1.5. Гамшиг, аюулт үзэгдэл ослын үед хүн хүч техник, хэрэгсэл дайчлан гаргах төлөвлөгөөний боловсруулалт, үр дүнг тооцсон байдал			
			3.1.1.6. Дайчлан гаргах хүн хүч, багаж техник, материал хэрэгслийн тооцоо судалгаа			

			3.1.1.7. Дайчлагдан гарах хүч хэрэгслийн бэлэн байдал		
	3.1.2. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө	3.1.2.1. Алба, мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний боловсруулалт, хянуулж батлуулсан эсэх, хэрэгжилт			
		3.1.2.2. Төлөвлөгөөнд тодотгол хийсэн байдал			
	3.1.3. Аж ахуйн нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөө	3.1.3.1. Аж ахуйн нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хянаж баталгаажуулсан байдал			
		3.1.3.2. Төлөвлөгөөнд тодотгол хийсэн байдал			
	3.1.4. Харилцан ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт, үр дүн	3.1.4.1. Төрийн цэргийн болон Хууль сахиулах байгууллагуудтай харилцан ажиллах төлөвлөгөө, хэрэгжилт, үр дүнг тооцсон байдал			
		3.1.4.2. Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо, сонирхол нэгт клубүүдтэй хамтран ажиллах төлөвлөгөө, санамж бичгийн хэрэгжилт, үр дүнг тооцсон байдал			
	3.1.5. Бэлэн байдлыг хангах, Бэлэн байдлыг шалгах, Аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөний хэрэгжилт	3.1.5.1. Төлөвлөгөөний боловсруулалт, хянуулж батлуулсан эсэх, хэрэгжилт, үр дүн			
	3.1.6. Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, бэлэн байдлын үзлэг зохион байгуулсан ажил, арга хэмжээ	3.1.6.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд зохион байгуулсан ажил, арга хэмжээний захирамж, удирдамж, төлөвлөгөө, тайлан, үр дүнг тооцсон байдал			
		3.1.6.2. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн бүрэлдэхүүнд зохион байгуулсан арга хэмжээний захирамж, удирдамж, хөтөлбөр, төлөвлөгөө, тайлан, үр дүнг тооцсон байдал			
		3.1.6.3. Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, бэлэн байдлын үзлэг зохион байгуулах хуваарь батлуулсан эсэх /4 жилээс доошгүй/			
	3.1.7. Онцгой комиссын Шуурхай штабын үйл	3.1.7.1. Шуурхай штабын үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт			

		ажиллагаа, бэлтгэл бэлэн байдал	3.1.7.2. Шуурхай штабын байрыг томилгоожуулж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр тоноглон эсэх			
		3.1.8. Онцгой байдлын байгууллагын бэлэн байдлын удирдамжийн хэрэгжилт, үр дүн	3.1.8.1. Онцгой байдлын байгууллагын бэлэн байдлын удирдамжийн хэрэгжилтийг хангуулж, үр дүнг тооцсон эсэх			
3.2	Гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналт	3.2.1. Улсын хяналтын байцаагчийн үйл ажиллагаа	3.2.1.1. Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт зохион байгуулсан материал /удирдамж, хяналт шалгалтад хамрагдах объектын судалгаа, хяналтын хуудас, хяналт шалгалтын тэмдэглэл, илтгэх хуудас, хүснэгт мэдээ/			
			3.2.1.2. Гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулсан материал /удирдамж, хяналт шалгалтын тэмдэглэл, илтгэх хуудас, хүснэгт мэдээ/			
			3.2.1.3. Хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийн бүртгэл, гүйцэтгэлийн хяналт шалгалтаар арилгуулсан зөрчил, үр дүнг тооцсон байдал			
			3.2.1.4 Хяналт шалгалт зохион байгуулсан тайлан, мэдээг хугацаанд нь ирүүлсэн байдал			
			3.2.1.5. Удирдамжит хяналт шалгалтад хамрагдаж барилга байгууламж бүрэн хамрагдсан эсэх /харьяалах газар нутгийн барилга байгууламжийг бүрэн хамруулсан эсэхэд үнэлгээ өгнө/			
			3.2.1.6. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, бүртгэл, хэрэг зөрчлийн шийдвэрлэлт			
			3.2.1.7. Улсын хяналтын байцаагчийн эрх зүйн баримт бичгийн боловсруулалт /Заавал биелүүлэх албан шаардлага, мэдэгдэл, дүгнэлт, акт, зөвлөмж, ажиллагаа зогсоох тогтоол г.м/			
			3.2.1.8. Улсын хяналтын байцаагч хэрэг зөрчилд шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан байдал, бүртгэл судалгаа			
			3.2.1.9. Зөрчлийн хэрэг үүсгэн шалган шийдвэрлэж, прокурорт хянуулсан байдал, бүртгэл			

			3.2.1.10. Зөрчлийн хэрэг бүртгэлтийн нэгдсэн мэдээллийн санд зөрчлийн хэрэг бүртгэлтийг бүртгүүлж, ажиллагаа явуулсан байдал			
			3.2.1.11. Засгийн газар, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийн бараа, материалын төв, орон нутаг дахь хуваарилалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалтад хяналт шалгалт хийсэн эсэх /гамшгаас хамгаалах улсын хяналт/			
			3.2.1.12. Гамшиг, аюулт үзэгдэл ослын бүртгэл, судалгаа /гамшгаас хамгаалах улсын хяналт/			
			3.2.1.13. Барилга байгууламжийн зураг төсөл хяналт хийсэн байдал, Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисст ажиллаж үүрэг даалгаврын биелэлтийг хангуулсан материалыг иргэн хуулийн этгээдээс гаргуулж авсан байдал /гал түймрийн улсын хяналт/			
			3.2.1.14. Улсын онц чухал болон онц аюултай объектуудын бүртгэл, судалгаа, хяналт шалгалт хийгдсэн байдал /гал түймрийн улсын хяналт/			
			3.2.1.15. Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт олгосон материал, бүртгэл /гал түймрийн улсын хяналт/			
			3.2.1.16. Нутаг дэвсгэрийн хэмжээнд гарсан гал түймрийн бүртгэл, судалгаа /гал түймрийн улсын хяналт/			
3.3	Гэрээт гал түймрийн улсын хяналт	3.3.1. Хяналт шалгалт зохион байгуулсан материал, бүртгэл, судалгаа	3.3.1.1. Хяналт шалгалтын төлөвлөгөө гаргаж баталгаажуулсан байдал			
			3.3.1.2. Хяналт шалгалтын бүртгэл хөтлөлт			
			3.3.1.3. Төлөвлөгөөт хяналт шалгалтын материал /удирдамж, хяналт шалгалтын тэмдэглэл, илтгэх хуудас, эрх зүйн баримт бичиг/			
			3.3.1.4. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын материал, үр дүнг тооцсон байдал /удирдамж, хяналт шалгалтын тэмдэглэл, илтгэх хуудас, эрх зүйн баримт бичиг/			
			3.3.1.5. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын материал, үр дүнг тооцсон байдал /удирдамж, хяналт шалгалтын тэмдэглэл, илтгэх хуудас, эрх зүйн баримт бичиг/			

			3.3.1.6. Гүйцэтгэлийн хяналт шалгалтын материал, үр дүнг тооцсон байдал /удирдамж, хяналт шалгалтын тэмдэглэл, илтгэх хуудас, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт/			
			3.3.1.7. Объектын судалгаа, тодотгол хийсэн байдал			
		3.3.2. Гэрээт байгууллагатай хамтран сургалт зохион байгуулсан байдал	3.3.2.1. Сургалт зохион байгуулах батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөө			
			3.3.2.2. Сургалт зохион байгуулсан илтгэх хуудас, бүртгэл, үр дүнг танилцуулсан байдал			
			3.3.2.3. Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө, карт, хэрэгжилт			
			3.3.2.4. Гал түймэр унтраах тактик, тархалтын дадлага сургууль зохион байгуулсан сургалтын материал, нотломж			
		3.3.3. Өдөр тутмын хяналт шалгалтыг зохион байгуулж зөрчлийг арилгуулсан байдал	3.3.3.1. Өдөр тутмын хяналт шалгалтын бүртгэл, хоногийн мэдээ гаргаж танилцуулсан байдал			
			3.3.3.2. Зөрчил арилгуулахаар хүргүүлсэн эрх зүйн баримт бичиг, үр дүнг тооцсон байдал			
			3.3.3.3. 7 хоногийн шуурхай хуралд танилцуулсан тайлан, төлөвлөгөө			
			3.3.3.4. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын бүртгэл, түүний хэрэгжилт			
		3.3.4. Гэрээний тайланг үнэлүүлсэн байдал	3.3.4.1. Гэрээнд заасан хугацаанд гэрээний үр дүнгийн хурал зохион байгуулж, үнэлсэн байдал, хурлын тэмдэглэл, гарсан шийдвэр			
			3.3.4.2. Гэрээт байгууллагын удирдлагад танилцуулсан авч хэрэгжүүлсэн арга хэмжээний танилцуулга, үр дүн			
			3.3.4.3. 7 хоног, сар, улирал, жилийн төлөвлөгөө, тайлангийн хэрэгжилт, үр дүн			
		3.3.5. Өргөдөл, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлт	3.3.5.1. Бүртгэл хөтөлсөн байдал			
			3.3.5.2. Өргөдөл, гомдол, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэсэн материал			
			3.3.5.3. Зөрчлийг арилгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ			
			3.3.5.4. Зөрчил шалган шийдвэрлэсэн материал, прокурорын байгууллагад хянуулсан байдал			

3.4	Холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын бэлэн байдал, ашиглалт, төлөвлөлт	3.4.1. Шуурхай удирдлага зарлан мэдээлэх үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийн бэлэн байдал, ашиглалт, бүртгэл, судалгаа	3.4.1.1. Дуудлага, мэдээллийн бүртгэл хөтлөлт			
			3.4.1.2. Болзошгүй гамшиг ослын үед холбоо зохион байгуулах дадлага сургууль зохион байгуулсан байдал, үр дүн			
			3.4.1.3. Харилцаа холбооны сувгаар холбоонд орсон бүртгэл			
			3.4.1.4. Харилцаа холбооны тоног төхөөрөмжийн батарей цэнэглэлтийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалт			
			3.4.1.5. Харилцаа холбооны техник ашиглалтын паспорт, засвар үйлчилгээ хийсэн бүртгэл, судалгаа, үр дүн			
	3.4.2. Мэдээллийн технологийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, программ хангамжийн бэлэн байдал, ашиглалт, бүртгэл, судалгаа	3.4.2.1. Мэдээллийн технологийн шийдэл, программ хангамжийн ашиглалт				
		3.4.2.2. Сүлжээний дэд бүтэц, шийдэл, интернэтийн урсгалын хэвийн ажиллагаа				
		3.4.2.3. Техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, төлөвлөлт, бүртгэл, судалгаа				
		3.4.2.4. Мэдээллийн системийн ашиглалт, өгөгдлийн сангийн хяналт, бүртгэл				
		3.4.2.5. Цахим хуралд, нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах үеийн технологийн холболт, бүртгэл				
		3.4.2.6. Теле хяналтын камер, дроны ашиглалт, бүртгэл				
	3.4.3. Кибер мэдээллийн аюулгүй байдлыг хангасан байдал	3.4.3.1. Хэрэглээний болон аюулгүй байдлыг хангах лицензтэй программ хангамжийг нэвтрүүлсэн бүртгэл				
		3.4.3.2. Албаны цахим мэдээллийн архивлалт, цахим мэдээллийн аюулгүй байдал				
		3.4.3.3. Сүлжээний тоног төхөөрөмж дэх кибер аюулгүй байдлын зохион байгуулалт				
	3.5	Гамшгийн аюулын зарлан мэдээлэл	3.5.1. Гамшиг, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, эрт зарлан мэдээллийн системийн төлөвлөлт ашиглалт, иргэд, олон нийтэд хүргэсэн бүртгэл	3.5.1.1. Иргэд, олон нийтэд сэрэмжлүүлэг, мэдээлэл хүргэсэн байдал		
3.5.1.2. Шуурхай бүлэгтэй холбоонд орсон, мэдээ мэдээлэл хүлээн авсан бүртгэл						
3.5.1.3. Зарлан мэдээллийн тоног төхөөрөмжийн байршил, ашиглалтын судалгаа						

		3.5.2. Зарлан мэдээлэл хүргэх бүдүүвч, бие бүрэлдэхүүний утас, гэрийн хаяг, цахим хаягийн тодотгол, зарлан мэдээлэл хүргэсэн байдал	3.5.2.1. Зарлан мэдээлэл хүргэх бүдүүвч, ажилласан байдал, нотломж /улирал/			
			3.5.2.2. Бие бүрэлдэхүүний утас, гэрийн хаяг, цахим хаяг тодотгол /улирал/			
3.6	Барилга байгууламж, техник, багаж хэрэгслийн бэлэн байдал, хадгалалт, хамгаалалт	3.6.1. Автомашин, техник хэрэгслийн бэлэн байдал, хувийн хэрэг хөтлөлт, хадгалалт, хамгаалалт ӨҮ, ТҮ-1, ТҮ-2, ТҮУ хийсэн бүртгэл	3.6.1.1. Техник үйлчилгээг төсөвт суулгасан байдал, гарсан тушаал шийдвэр			
			3.6.1.2. Техник, хэрэгслийн хувийн хэргийн хөтлөлт, хадгалалт, хамгаалалт			
			3.6.1.3. Автомашин, ажирлагааны зүгшрүүлэлт, ашиглалтын (тус бүрийн ашиглалтын гарын авлага, зааврын дагуу унтраах бодисын хадгалалт, үндсэн хөөрөг– насос, тусгай тоноглолын ажирлагаа гэх мэт) бэлэн байдлыг хангах чиглэлээр хийгдсэн ажил, арга хэмжээ			
			3.6.1.4. Техник үйлчилгээ хийгдсэн талаарх илтгэх хуудас, бүртгэл, нотломж			
			3.6.1.5. Автомашин, механизмын ашиглалтад бэлэн байдлын хувийг тооцсон байх.			
			3.6.1.6. Техник, багаж хэрэгслийн эвдрэл, саатал, гэмтлийн бүртгэл хөтөлсөн байх.			
			3.6.1.7. Техник ашиглалтын явцад илэрсэн зөрчил, гэмтлийн мөрөөр засвар, сэргээн босголтын арга хэмжээ авсан байх.			
			3.6.1.8. Улирал, жилийн ашиглалтын онцлогт тохируулан хадгалалтын нөхцөлийг хангуулсан байх.			
			3.6.1.9. Галын аюулгүй байдал, цахилгаан, шатах тослох материалтай холбоотой аюулгүй ажирлагааны шаардлагыг хангасан байх.			
				3.6.2. Амьсгалын бие даасан төхөөрөмж /цаашид АБДТ гэх/,	3.6.2.1. АБДТ-тэй ажирлах үед дагаж мөрдөх дүрмийн дагуу засвар үйлчилгээний төв, засварын хэсгийг байгуулсан байдал, түүний үйл ажирлагаа	

		хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдал	3.6.2.2. АБДТ-тэй ажиллах үед дагаж мөрдөх дүрэмд заасны дагуу АБДТ-тэй ажиллах, дадлага сургалтыг зохион байгуулах тусгай тоноглол бүхий талбай, давчуу орчинд ажиллах сургалтын байгууламжийг бүрдүүлж, сургалт зохион байгуулсан байдал			
			3.6.2.3. АБДТ эзэмшигч алба хаагчдын эмчийн үзлэгт хамруулж, онолын мэдлэг, дадлага ажлын шалгалт авч, анхан шатны болон давтан сургалтыг зохион байгуулсан эсэх			
			3.6.2.4. АБДТ-тэй ажиллах үед дагаж мөрдөх дүрмийн хавсралтаар батлагдсан хөтлөгдөх баримт бичгүүдийн хөтлөлт			
			3.6.2.5. Нөөц төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн бэлэн байдлыг хангуулсан байдал			
		3.6.3. Тусгай зориулалтын тоног төхөөрөмж багаж хэрэгсэл, хүн нэг бүрийн хамгаалах тусгай хувцас, хэрэгслийн бэлэн байдал, үзлэг шалгалт, засвар үйлчилгээ хийсэн байдал	3.6.3.1. Тусгай зориулалтын тоног төхөөрөмж багаж хэрэгсэл, хүн нэг бүрийн хамгаалах тусгай хувцас, хэрэгслийн хангалт, хангалтыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ			
			3.6.3.2. Техникийн тусгай тоноглол, тоног төхөөрөмж, хамгаалах тусгай хувцас, багаж хэрэгсэлд үзлэг, туршин шалгах, үйлчилгээ хийсэн байдал			
		3.7	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	3.7.1. Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа	3.7.1.1. Алба хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх болон хугацаат үзлэгт хамруулсан байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	
3.7.1.2. Анхан болон лавлагаа шатлалын эмнэлэг, нарийн мэргэжлийн эмчийн хяналтад оруулсан байдал						
3.7.1.3. Эмчлэх, сувилах эрхийн хүчинтэй байдал						
3.7.1.4. Эмч, сувилагч нарын ажлын байранд хөтлөгдөх баримт бичгийн бүртгэл, хөтлөлт, хугацаат тайлан мэдээ хүргүүлсэн байдал						
3.7.2. Эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдал	3.7.2.1. Эмчилгээний аппарат тоног, төхөөрөмжийн техник ашиглалтын паспортын тэмдэглэл, мэргэжлийн байгууллагаар засвар үйлчилгээ, тохируулга хийлгэсэн байдал					
	3.7.2.2. Яаралтай тусламжийн болон нэн шаардлагатай үед хэрэглэх эмийн нөөц, жагсаалт, бүртгэл хяналт					

			3.7.2.3. Эмнэлгийн аюултай хог хаягдал устгах гэрээний хэрэгжилт, хугацаа			
			3.7.2.4. Эрүүл мэндийн цахим бүртгэлийн системийн ашиглалт			
3.8	Химийн хорт болон аюултай бодисын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	3.8.1. Химийн хорт болон аюултай бодис ашиглах, хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаа	3.8.1.1. Ослын үед аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааг шуурхай удирдлага, зохицуулалтаар хангаж ажилласан байдал, бүртгэл судалгаа			
			3.8.1.2. Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагын бүртгэл			
			3.8.1.3. Аюулгүй байдлыг хангах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтарсан хяналт шалгалт зохион явуулж зөвлөмж, дүгнэлт өгч ажилласан байдал			
			3.8.1.4. Дадлага, сургалт зохион байгуулсан хөтөлбөр, удирдамж, төлөвлөгөө батлуулж тайлагнасан байдал			
		3.8.2. Цацраг, химийн бодисын нөлөөллөөс хамгаалах хүн нэг бүрийн хамгаалах хувцас, багаж хэрэгслийн чанар байдал, ашиглалт, хадгалалтад хяналт тавьдаг эсэх	3.8.2.1. Хүн нэг бүрийн хамгаалах хувцас, багаж хэрэгслийн бүртгэл, судалгаа			
			3.8.2.2. Ашиглалт, хадгалалтын хугацаанд хяналт тавьж, бүртгэлжүүлсэн байдал			
			3.8.2.3. Ослын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулахад заавар, зөвлөмж, хяналт тавьж ажилласан байдал			
3.9	Анги, салбар, нэгжийн үйл ажиллагаа	3.9.1. Гамшиг аюулт үзэгдэл, осол, томилгоот ээлжийн томилгоо, үүрэг гүйцэтгэл, бүртгэл	3.9.1.1. Гамшигийн голомтод үүрэг гүйцэтгэх алба хаагч, багаж, техник хэрэгслийн томилгоожуулж үүрэг гүйцэтгэсэн байдал			
			3.9.1.2. Зарлан мэдээллийн дохиогоор ажилласан удирдамж, илтгэх хуудас, нотломж			
			3.9.1.3. Зарлан мэдээллийн дохио дамжуулах бүдүүвч, хаягийн тодотгол хийсэн байдал			
		3.9.2. Анги, салбар, нэгж, алба хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө,	3.9.2.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тайлангийн баталгаажуулалт, үр дүнг тооцсон байдал			
			3.9.2.2. Алба хаагчдын ажил дүгнэсэн баримт бичиг			

		тайлан, ажил дүгнэсэн баримт бичиг	3.9.2.3. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, үр дүн			
			3.9.2.4. Алба хаагчийн өдөр тутмын ажлын тэмдэглэл, хөтлөлт			
